



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/275

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн 1,9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хүнс, хөдөө аж ахуйн газар, мал эмнэлгийн лабораторийн барилгын угсралтын ажлын гүйцэтгэгч шалгарах явцад нийт төсөвт өртөг нэмэгдэн батлагдсантай холбогдуулан худалдан авах ажиллагааг хэрхэн зохион байгуулах талаар шийдвэр гаргаж ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Т.Жаргалсайхан - Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд: Н.Ганзориг - Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Б.Бямбажав - Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Д.Батцэнгэл - Мал эмнэлгийн газрын дарга


Ц.Пүрэвсүрэн - Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө  
оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

Н.Эрдэнэцэцэг - Худалдан авах ажиллагааны албаны ахлах  
мэргэжилтэн

Нарийн бичгийн

дарга: Ч.Эрдэнэбат - Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн

2. Төсөвт өртөг нэмэгдсэн асуудлыг судлан хууль дүрмийн хүрээнд шийдвэр гаргахыг ажлын хэсгийн ахлагч (Т.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 1425  
Zan A/275 Kh